



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/339

Мандалговь

Г Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн
хэлбэрээр орлуулан хаах иргэдийн тухай

Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их хурлын 2009 оны 33-р тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын 2.3, тухайн жилийн Цэрэг татлагын товчооны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2016 оны I, II ээлжийн цэрэг татлагаар болон 2016 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн үеэр цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол ханган мөнгөн төлбөр төлөх иргэдийн нэрсийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, 2013-2015 оны цэрэг татлагаар болон шинэчилсэн тоо бүртгэлээр мөнгөн төлбөр төлүүлэхээр шийдвэр гарсан боловч төлөөгүй иргэдийг нөхөн төлүүлэх нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Хавсралтад дахь цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол ханган мөнгөн төлбөр төлөх иргэдийг нөхөн төлүүлэх арга хэмжээг журмын дагуу авахыг Цэргийн штабын дарга /хурандаа Б.Амаржаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200918

